**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/235-НА-СТА-ТШЗ

| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: | Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 | Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| | Аудитын менежер: | Б.Батмөнх |
| Сүхбаатар сум | Утас: 7036-3036 | Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| 2023 он | Ахлах аудитор: | Т.Болор |
| | Утас: 7036-2442 | Цахим хаяг: bolort@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын дүгнэлт 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-11

3. Санхүүгийн тайлангийн тодруулга 12-15

   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 12

   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 12

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 13

   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 13

   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 14

4. Аудитын тайлан 16-18

   4.1 Ерөнхий зүйл 16

   4.2 Материаллаг байдал 16

   4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 16

   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17

   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17

   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18

5. Аудитын илрүүлэлт 19

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 20


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.13 № СЭА-2023/235/-НА-СТА-ТШЗ

танай ________-ны № ________-т

САЙХАН СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТСИЙН ДАРГА, ХОШУУЧ Б.НЯМХИШИГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.9 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 0.1 хувиар хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 76.6 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой



018020007

тогтмол зардалд 44,205.6 мянган төгрөг, нормативт зардалд 17,896.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,466,807.90** | **33,884,820.21** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **30,466,807.90** | **33,884,820.21** |
| **35100** | **Түүхий эд материал** | **14,829,516.00** | **15,228,046.01** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,357,721.00 | 14,471,721.01 |
| 35130 | Эм боох материал | 471,795.00 | 756,325.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **15,637,291.90** | **18,656,774.20** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 751,248.00 | 860,590.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,768,562.70 | 8,124,872.70 |
| 35450 | Барилгын засварын материал | 278,500.00 | 278,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 297,520.00 | 1,344,650.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,541,461.20 | 8,048,161.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **345,406,294.35** | **422,864,261.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **345,406,294.35** | **422,864,261.86** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **343,606,294.35** | **421,064,261.86** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 351,504,924.45 | 401,504,924.45 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -68,038,433.84 | -81,777,895.54 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 110,318,381.30 | 65,305,749.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -86,494,969.08 | -25,414,682.70 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 58,577,936.00 | 78,125,870.94 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -27,479,621.05 | -34,851,844.53 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,941,240.00 | 24,737,264.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,723,163.43 | -6,565,123.76 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,800,000.00** | **1,800,000.00** |
| 39301 | Программ хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -6,417,692.31 | -6,417,692.31 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **375,873,102.25** | **456,749,082.07** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **375,873,102.25** | **456,749,082.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **375,873,102.25** | **456,749,082.07** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **374,073,102.25** | **454,949,082.07** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 386,719,533.40 | 374,073,102.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -12,646,431.15 | 80,875,979.82 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **375,873,102.25** | **456,749,082.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **328,312,683.20** | **447,297,531.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,377,983.20** | **109,136,331.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **13,377,983.20** | **109,136,331.25** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **0** | **31,620,526.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0 | 31,620,526.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 3,900,000.00 | 75,492,174.94 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 9,477,983.20 | 2,023,630.31 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,934,700.00** | **338,161,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **314,934,700.00** | **338,161,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 314,934,700.00 | 338,161,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **334,414,114.35** | **366,421,551.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **334,414,114.35** | **366,421,551.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **333,728,459.31** | **365,856,850.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **240,722,728.03** | **253,949,190.36** |
| 210101 | Үндсэн цалин | 152,912,429.85 | 173,978,123.59 |
| 210102 | Нэмэгдэл | 85,615,203.90 | 75,550,666.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,195,094.28 | 3,420,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,946,797.33** | **5,078,983.83** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,946,797.33 | 5,078,983.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,529,749.60** | **44,205,624.55** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,811,971.11 | 3,683,699.99 |
| 210302 | Түлш, халаалт | 15,757,819.49 | 29,474,493.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,959,959.00 | 11,047,431.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,890,300.00** | **10,282,377.58** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,231,750.00 | 1,399,778.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,414,800.00 | 6,201,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,783,000.00 | 2,116,499.58 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,300.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 490,950.00 | 504,800.00 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | 2,909,500.00 | 0 |
| **2105** | **Нормативт зардал** | **13,077,932.00** | **16,877,240.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 626,560.00 | 672,470.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,451,372.00 | 16,204,770.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,799,100.00** | **2,307,200.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 176,000.00 | 147,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,623,100.00 | 2,159,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **200,000.00** | **545,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 545,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,663,924.00** | **1,515,001.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 866,400.00 | 693,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,428.00 | 143,928.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 554,500.00 | 555,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,596.00 | 1,798.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,897,928.35** | **31,095,833.43** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 258,000.00 | 216,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,639,928.35 | 30,878,933.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **685,655.04** | **564,700.68** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **200,000.00** | **390,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 390,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **485,655.04** | **174,700.68** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 485,655.04 | 174,700.68 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-6,101,431.15** | **80,875,979.82** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **6,545,000.00** | **0** |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 6,545,000.00 | 0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-12,646,431.15** | **80,875,979.82** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **314,934,700.00** | **338,161,200.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,934,700.00** | **338,161,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **314,934,700.00** | **338,161,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 314,934,700.00 | 338,161,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **311,246,700.00** | **336,937,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **311,246,700.00** | **336,937,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **310,561,044.96** | **336,372,299.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **240,722,728.03** | **253,949,190.36** |
| 210101 | Үндсэн цалин | 152,912,429.85 | 173,978,123.59 |
| 210102 | Нэмэгдэл | 85,615,203.90 | 75,550,666.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,195,094.28 | 3,420,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,946,797.33** | **5,078,983.83** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,946,797.33 | 5,078,983.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,529,749.60** | **44,205,624.55** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,811,971.11 | 3,683,699.99 |
| 210302 | Түлш, халаалт | 15,757,819.49 | 29,474,493.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,959,959.00 | 11,047,431.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,757,848.00** | **10,221,099.58** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,011,048.00 | 1,345,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,284,800.00 | 6,201,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,783,000.00 | 2,116,499.58 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,300.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 618,700.00 | 498,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **12,897,398.00** | **17,896,400.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 456,800.00 | 644,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,440,598.00 | 17,251,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **16,549,600.00** | **2,561,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,770,500.00 | 254,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 176,000.00 | 147,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,603,100.00 | 2,159,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **200,000.00** | **545,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 545,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,698,924.00** | **1,697,001.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 901,400.00 | 875,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,428.00 | 143,928.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 554,500.00 | 555,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,596.00 | 1,798.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **258,000.00** | **216,900.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 258,000.00 | 216,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **685,655.04** | **564,700.68** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **200,000.00** | **390,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 390,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 485,655.04 | 174,700.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 485,655.04 | 174,700.68 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,688,000.00 | 1,224,200.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 3,688,000.00 | 1,224,200.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,688,000.00 | 1,224,200.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 3,688,000.00 | 1,224,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,688,000.00 | 1,224,200.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -3,688,000.00 | -1,224,200.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд-сан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 386,719,533.40 | 388,519,533.40 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 386,719,533.40 | 388,519,533.40 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -12,646,431.15 | -12,646,431.15 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 374,073,102.25 | 375,873,102.25 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 374,073,102.25 | 375,873,102.25 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 374,073,102.25 | 375,873,102.25 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 80,875,979.82 | 80,875,979.82 |
| 20 | 2022 оны 06-р сарын 30-наарх үлдэгдэл | 1,800,000.00 | 0 | 454,949,082.07 | 456,749,082.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт/ хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **338,161,200.00** | **337,986,499.32** | **174,700.68** | **99.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **338,161,200.00** | **337,986,499.32** | **174,700.68** | **99.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **337,741,200.00** | **337,596,499.32** | **144,700.68** | **99.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **254,006,200.00** | **253,949,190.36** | **57,009.64** | **99.98** |
| 210101 | Үндсэн цалин | 170,428,800.00 | 173,978,123.59 | -3,549,323.59 | 102.08 |
| 210102 | Нэмэгдэл | 79,157,000.00 | 75,550,666.77 | 3,606,333.23 | 95.44 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 3,420,400.00 | 3,420,400.00 | 0.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,146,700.00** | **5,078,983.83** | **67,716.17** | **98.68** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,146,700.00 | 5,078,983.83 | 67,716.17 | 98.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **44,207,100.00** | **44,205,624.55** | **1,475.45** | **100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,683,700.00 | 3,683,699.99 | 0.01 | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,474,500.00 | 29,474,493.56 | 6.44 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,048,900.00 | 11,047,431.00 | 1,469.00 | 99.99 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,221,100.00** | **10,221,099.58** | **0.42** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,345,000.00 | 1,345,000.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,201,300.00 | 6,201,300.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,116,500.00 | 2,116,499.58 | 0.42 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 60,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 498,300.00 | 498,300.00 | 0.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **17,896,400.00** | **17,896,400.00** | **0.00** | **100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 644,500.00 | 644,500.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,251,900.00 | 17,251,900.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,785,900.00** | **3,785,900.00** | **0.00** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,478,700.00 | 1,478,700.00 | 0.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 147,900.00 | 147,900.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,159,300.00 | 2,159,300.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **545,400.00** | **545,400.00** | **0.00** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 545,400.00 | 545,400.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,715,500.00** | **1,697,001.00** | **18,499.00** | **98.92** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 876,500.00 | 875,175.00 | 1,325.00 | 99.85 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 144,000.00 | 143,928.00 | 72.00 | 99.95 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 555,100.00 | 555,100.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 18,900.00 | 1,798.00 | 17,102.00 | 9.51 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **216,900.00** | **216,900.00** | **0.00** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 216,900.00 | 216,900.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **420,000.00** | **390,000.00** | **30,000.00** | **92.86** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **420,000.00** | **390,000.00** | **30,000.00** | **92.86** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 390,000.00 | **30,000.00** | **92.86** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **338,161,200.00** | **337,986,499.32** | **174,700.68** | **99.95** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **338,161,200.00** | **337,986,499.32** | **174,700.68** | **99.95** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 338,161,200.00 | 337,986,499.32 | **174,700.68** | **99.95** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **33** | **33** | **0.00** | **100.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0.00** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **16** | **16** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 | 0.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **16** | **16** | **0.00** | **100.00** |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 16 | 16 | 0.00 | 100.00 |

4317143938
МЮА0065 9055436

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс /*Сайхан сум дахь ШШГХ*/ нь “*Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх*” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Цагдан хорих, таслан сэргийлэх үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн, хүний амьдрах эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,
- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг сайжруулах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 06 дугаар сарын 03, 28-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сайхан сум дахь ШШГХ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар ШШГЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80,876.0 мянган төгрөгөөр буюу 21.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 30,466.8 | 33,884.8 | 3,418.0 |
| Үндсэн хөрөнгө | 345,406.3 | 422,864.3 | 77,458.0 |
| **Нийт хөрөнгө** | **375,873.1** | **456,749.1** | **80,876.0** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 375,873.1 | 456,749.1 | 80,876.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **375,873.1** | **456,749.1** | **80,876.0** |

4317143998
МЮА0065 9055436

Бараа материалын дансны үлдэгдэл 33,884.8 мянган төгрөг болж 3,418.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 28,821.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ШШГЕГ-аас 2,023.6 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 27,427.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /*анхны өртгөөр*/ 577,891.5 мянган төгрөг болж 27,331.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,224.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 107,112.7 мянган төгрөгийн орон сууц, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг ШШГЕГ болон анги салбараас үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-ын даргын 2022 оны А-5/1883 дугаар тушаалаар 81,005.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 456,749.1 мянган төгрөг болж 80,876.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 357,019.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Энэ нь түлш, халаалтын зардлыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 457 дугаар тогтоол, сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хоногийн хоол хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг нормыг Хууль зүй, дотоод, хэргийн сайдын 2017 оны А/214 дүгээр тушаал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид

олгох хүнсний хангалтын хэмжээг Засгийн газрын 2018 оны 261 дүгээр тогтоолын дагуу тооцоолж, төсөвт тусгаснаас тус тус шалтгаалсан байна.

Төсвийн төслийн саналаас 47,243.8 мянган төгрөгөөр бууруулж */байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,239.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 35,417.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./* 309,776.1 мянган төгрөгөөр баталсан байна.

МЮА0065 9055436

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 28,385.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон */байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,892.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 7,555.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн/* байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 338,161.2 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 338,161.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 337,986.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 144.6 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 0.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 30.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 332,443.7 | 332,299.1 | 144.6 | 99.9 |
| 2 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 3,625.0 | 3,624.9 | 0.1 | 100.0 |
| 3 | Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ | 1,672.5 | 1,672.5 | - | 100.0 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 420.0 | 390.0 | 30.0 | 92.9 |
| | **Дүн** | **338,161.2** | **337,986.5** | **174.7** | **99.9** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130912402 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сайхан сум дахь ШШГХ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь ШШГХ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 334,414.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,344.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШШГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар "Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай" албан даалгавар, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргын 2022 оны 06/41 дугаар "Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай", 06/137 дугаар "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сум дахь ШШГХ-ийн мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн боловч 8,369.0 мянган төгрөгийн 1 /*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ*/ мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд мэдээлсэн байдлын хэрэгжилт 88.5 хувьтай байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,250.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 4,250.0 | 1 | 4,250.0 | 100 |
| **Нийт дүн** | **1** | **4,250.0** | **1** | **4,250.0** | **100** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 620.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*1.1 <u>Илрүүлэлт:</u>* Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд шийдвэр гүйцэтгэгчийн шуудан холбооны зардлыг төсөвлөсөн боловч батлагдаагүйгээс "*80229-шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээний зардал*"-ын төсөв хүрэлцэхгүй болж "*80101-үндсэн үйл ажиллагааны зардал*"-аас 3 шийдвэр гүйцэтгэгчийн утасны төлбөр 620.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "*Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална*", 5.1.2 дахь *"Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*1.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>* Зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4317143998
МНОА0065 9055436

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| 3 шийдвэр гүйцэтгэгчийн утасны төлбөрийг “үндсэн үйл ажиллагааны зардал”-аас санхүүжүүлсэн | 1 | 620.0 | | | | | 1 | 620.0 | | | | |
| **Дүн** | **1** | **620.0** | | | | | **1** | **620.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлээгүй. | 1.0 | 8,369.0 | | | | | 1.0 | 8,369.0 |
| **Дүн** | **1.0** | **8,369.0** | | | | | **1.0** | **8,369.0** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1.0** | **8,369.0** | | | | | **1.0** | **8,369.0** |